



VI. 02-р сарын 01-нээс 02-р сарын 28-ныг хүртэлх өнгөрсөн сарын цаг агаарын тойм мэдээ


Хур тундас: Цас ороогүй.

Салхи: Ихэнх хугацаанд салхи секундэд 6-11 метр байв.

Агаарын температур: Энэ сард хамгийн дулаан нь 27-ны өдөр 6,1 градус дулаан, хамгийн хүйтэн нь 07-ны шөнө -32,2 градус хүйтэн. Агаарын дундаж температур -14,3 градус хүйтэн байсан.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Говьсүмбэр аймгийн нутгаар агаарын дундаж температур 03 дугаар сард -6...-14°C хүйтэн байдаг ба энэ сард ОЖД-аас дулаан байх төлөвтэй байна.



Зураг 1. 2025 оны 03-р сарын агаарын дундаж температурын урьдчилсан төлөв, C°


[X-агаарын температур ОЖД-аас хүйтэн

X-агаарын температур ОЖД-аас дулаан,

H-агаарын температур ОЖД-ийн орчим]

Нэгдүгээр арав хоногийн ихэнх хугацаа, хоёрдугаар арав хоногийн дунд, гуравдугаар арав хоногийн эхэн болон дунд үеүдэд ихэнх нутгаар ОЖД-аас 1-3°C-аар дулаан харин хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүл, гуравдугаар арав хоногийн сүүлээр ОЖД-аас 1-3°C-аар хүйтэн байх төлөвтэй байна.

Хур тунадас (цас): Энэ сард 0-4 мм тунадас ордог бол ОЖД-ын орчим орох төлөвтэй байна.




Зураг 2. 2025 оны 03-р сарын нийлбэр хур тунадасны урьдчилсан төлөв, мм

[Б – хур тунадас ОЖД-аас бага

И–хур тунадас ОЖД-аас ахиу,

Н–хур тунадас ОЖД-ийн орчим]

Нэгдүгээр арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлч үеүдэд ихэнх нутгаар хур тунадас орж, зарим газраар салхи шуургатай байна.



Зураг 3. Говийн аймгуудын нутгийн 2025 оны 03-р сарын температур, хур тунадасны явц

[Хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан,

үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температур, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, ногоон – хур тунадасны хэмжээ]

ГОВЬСҮМБЭР УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ